Тахийн мэдээ

№. 8/2018 оны 12-р сар

ДАРХАН ЦААЗАТ ГАЗАР ДАХЬ МАЛЧИД: ХАМТРАН АЖ ТӨРӨХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Хэдэн зууны туршид н өвлийн улиралд нутгийн малчдын гол бэлчээр нь болж ирсэн дархан цаазат газрыг хэрхэн хамгаалах вэ? Малчдын мал сүрэг улам өсөн нэмэгдсээр байвал цаашид яах вэ? гэсэн асуултууд бидэнд тулгараад байна. Бид хамтдаа түүнийг шийдэж чадна.

Тахь болон түүний амьдрах орчинг хамтдаа хамгаалцгаая.

Тахийг хайрлан хамгаалдаг ЭРХЭМ АНДУУДАА

Эрт дээр үеэс Зүүнгарын говь малчдын нутаг байлаа. Зуны улиралд нүүдэлчид таван хошуу малаа Монгол Алтайн нурууны уулсаар бэлчээнэ. Энэхүү сүрлэг өндөр уулс нь далайн түвшнээс 1400-1650 м дээш өндөрт орших Зүүнгарын сав газрын 9000 км2 талбайтай тэгш өндөрлөгийн хойд хэсгийг хүрээлэнэ. Монгол орны хатуу ширүүн өвлийг нүүдэлчид энэ бүс нутаг даван туулдаг. Одоо ч энэ байдал хэвээрээ.

Харин өнөөдөр энэхүү тэгш тал нутгийг "Говийн их дархан цаазат газар"-ын "Б" хэсэг (Дархан цаазат газар) гэж нэрлэх болжээ. Энэ нь зөвхөн мал сүргийн идээшлэх газар биш бөгөөд өөр хаана ч байхгүй ховордож буй амьтан, ургамлын төрөл зүйлийн өлгий нутаг юм. Тахь (Пржевальскийн адуу) зэрэг зүйлүүд устахаас өмнө хамгийн сүүлд зэрлэг байгальдаа яг энд амьдарч байжээ. Өнөөдөр ч яг энэ унаган нутагтаа тахь эргэн нутагшихаар хичээж байгаа билээ. Мөн энэхүү дархан цаазат газар нь дэлхийн хэмжээнд мянга мянган хулангийн амьдрах нэн чухал орон зай болж байна. Хар сүүлт зээр, аргаль, янгир, олон жижиг хөхтөн амьтад, мөн 100 гаруй зүйлийн шувуунаас гадна олон зүйлийны төлөөлөл бүхий ургамлын аймгийг энд дурьдахгүй байж болохгүй. Дархан цаазат газрыг хамгаалах олон чухал шалтгаанууд бий! Түүнчлэн 60 000 гаруй толгой малтай, 100 гаруй нүүдэлчин өрх аж төрдөг. Ийм байж таарах уу? Хүн, байгаль бие биенээ сүйтгэдэггүй гэж үү? Тэд үнэхээр хамтдаа амар тайван оршин байж чадах уу?

Тиймээ, чадна гэж ЮНЕСКО үзэж Монгол улсын засгийн газартай хамтран 1991 онд Говийн их дархан цаазат газрыг Азид хамгийн том, дэлхийн хэмжээнд 4 дэхь томд тооцогдох ХҮН БА ШИМ МАНДЛЫН нөөц газар гэж бүртгэсэн. Онгон дагшин байгаль, уламжлалт амьдралын хэв маяг хоёрын аль алинд адил ач холбогдолтой амьдрах орчин болж байгаа тул энэ нутаг Хүн ба шим мандлын нөөц газрын тухай үндсэн ойлголттойгоо төгс нийцдэг.

Бүх юм тэгээд сайхан болох уу? Энэ бол тийм ч энгийн зүйл биш. Зүүнгарын говийн нүүдэлчид ч өнөөдөр iPad болон ухаалаг утсыг хэрэглэж байна. Тэдний ямааны ноолуур дэлхийн зах зээл дээр хамгийн сайн байгалийн нарийн ширхэгтэй ноолуурт тооцогддог. Малын тоо улам өсч илүү бэлчээр хэрэгтэй болох нь гайхах зүйл биш. Сайн үр дүнд энэ нь хүргэх үү? Хур бороо татарч цас их орвол бэлчээр хомсдох нь хэмээн зарим малчид санаа зовж байна.

Ийм нөхцөл байдалд Дархан цаазат газрыг хэрхэн хамгаалж, ажиллуулах вэ? Эдгээр нь ОУТГ-ийн хувьд тал талаас нь тунгаан эргэцүүлж байдаг асуултууд юм. Ингэхдээ бид зөвхөн тахь болон энэ бүс нутгийн өвөрмөц зохицуулалт бүхий төрөл зүйлийг биш, түүнтэй эн тэнцүү өвөрмөц онцлог бүхий нүүдэлчдийн амьдралын уламжлалт хэв маягийг хамгаалахыг хүсдэг. Дархан цаазат газар өөрийн үнэ цэнээ хадгалан үлдэх болно, түүнчлэн энэхүү эмзэг экосистемд зохицсон аялал жуулчлалыг хөгжүүлснээр шинэ үнэ цэнийг ч бүтээж болно. Хэрэв энэ нь хэрэгжвэл нутгийн айл өрхүүдийн хувьд амьжиргааны өөр орлого бий болж Улаанбаатар руу нүүх шаардлагагүй болно. Зэрлэг амьтан, онгон байгалийг ийнхүү хамгаалах нь хамтарсан үйл хэрэг, хамтын бүтээлийг бий болгож байгаа болохоос биш тэднийг цөлж тусгаарласан хэрэг огт биш юм. Хүн төрөлхтөн ба ховор төрөл зүйлийн хэрэгцээ сонирхол зохицдоггүй тул энэ нь тийм ч амар зүйл биш. Тодорхой дүрэм журам зайлшгүй хэрэгтэй. Гэхдээ хамтдаа - зөвхөн бид - зөрчилдөөнийг шийдэж чадна. Энэ бол бидний оролцох, хийх ёстой зүйл. Та ч мөн адил бидэнтэй хамтрах уу?

Др. Райнхард Шнидрих, Олон Улсын Тахь Группын ерөнхийлөгч

Зураг: Н. Алтансүх

Байгаль хамгаалагчид:
Малчин Л. Галбадрах, Н. Ариунжаргал нар.

2018 оны хавраас эхлэн Лена Михлер ГИДЦГ-ын "Б" хэсэг, түүний орчны бүсэд судалгаа хийж байна.Тэрээр Галбадрах болон түүний эхнэр Ариунжаргал нартай ярилцлага хийж тахийн сэргээн нутагшуулснаар малчдад үзүүлж буй шууд нөлөө болон ГИДЦГ-ын Б хэсгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах арга хэмжээний талаар мэдээ бэлтгэж Тахийн Мэдээ сонинд нийтлүүллээ.

Лена: Та хэр удаан энэ нутагт мал хариулж байна вэ?
Галбадрах: Би мэдээ орсон цагаасаа хойш 44 жил мал маллаж байна.

Лена: Та ямар мал хариулж байна вэ? Хэдэн малтай вэ?
Галбадрах: Таван хошуу малтай. 700 ямаа, 400 хонь, 25 адуу, тэмээ, үхэр цөөхөн 2-3 бий.

Лена: Мал маллахад тусалдаг хүүхдүүд бий юу?
Галбадрах: Манайх 4 хүүхэдтэй. Хоёр нь тусдаа амьдралтай. Нэг оюутан байна. 2 дахь хүү маань бидэнтэй цуг амьдарч тус дэм болж байна.

Лена: Мал маллаж байгаа амьдарлын хэв маяг, арга ухаанаа үр хүүхдүүддээ өвлүүлэх талаар боддог уу? Галбадрах: Тэгэлгүй яахав. Манай хоёр дахь хүү л үргэлжлүүлж авч явна.
Ариунжаргал: Тиймээ, одоо бидэнд туслаж байгаа хоёр дахь хүүдээ өвлүүлж үлдээнэ.

Лена: Танайх хэр олон удаа нүүж бэлчээр сэлгэж байна? ГИДЦГ "Б" хэсгийн нутагт жилийн аль үед орж буудаг вэ?
Галбадрах: Хамгаалалттай нутагт бид есдүгээр сард ирж таван сарын сүүл хүртэл нутаглаж байгаад уулруугаа гарч зусдаг.

Лена: Хамгаалалттай нутагт мал маллах ямар байдаг вэ?
Галбадрах: Энэ нь тийм амар биш. Бид ДЦГ-ын хил хязгаарын дагуу зэрлэг амьтдаас зайдуу малаа бэлчээхийг боддог. Учир нь зэрлэг амьдыг үргээчих болов уу гэж санаа зовнидог.

Лена: ГИДЦГ "Б" хэсгийг 1975 онд байгуулагдахаас өмнө нөхцөл байдал өөр байсан уу?
Галбадрах: 1975,1976 онд дархан цаазат газрыг хамгаалалтанд авч байх үед өвөл хүндэрч зуд болсныг санаж байна. Өнөөдөр байдал их дээр болсон. Нутгийг минь хамгаалж, тахийг сэргээж нутагшуулсан нь сайн сайхан зүйл.
Ариунжаргал: Нөхцөл байдал бүрэн өөрчлөгдсөн шүү.

Лена: Хэзээ ямаагаа самнаж, хонио ноослодог вэ? Малчин айлын нэг жил ер нь яаж өнгөрдөг вэ? Хүүхдүүд чинь ирж ямаа самнаж ноолуур авахад тусалдаг уу? Тэмээний ноосыг хэзээ хайчлах вэ?
Галбадрах: Ихэвчлэн дөрвөн сарын аравдаас эхлээд ямаагаа самнана. Хонины ноосоо зургадугаар сарын сүүл, долдугаар сарын эхээр хяргана даа. Тэмээгээ тавдугаар сард ноослоно. Энэ завгүй үеэр хүүхдүүд ирж тусалдаг.

Лена: Хамгийн их ажилтай үе нь хэзээ байдаг вэ?
Галбадрах: Хавар хамгийн хэцүү, бас завгүй улирал. Мал төллөнө, ноолуураа авна. Ямаа самнах ажил ихэвчлэн нэг сар үргэлжилдэг.
Ариунжаргал: Гуравдугаар сарын 15-даас мал төллөнө, түүний дараа ямаагаа самнаж эхэлнэ.

Зураг: Лена Михлер

Лена: Хамгийн их орлогыг юунаас олдог вэ?
Галбадрах: Ямаа! Ямаа л шүү дээ!
Ариунжаргал: Нэг килограмм ноолуур 120'000 - 130'000 төгрөгт (48.00-52.00 ШФ) хүрнэ гэж бид сонссон.

Лена: Та нар зэрлэг амьтдыг харж байна уу? Тахь, хуланг олж харж байна уу?
Галбадрах: Тиймээ зөндөө! Энд байдаг зэрлэг амьтдыг бараг бүгдийг харсан. Тэднийг харахад бахархмаар шүү. Гол нь эндээс ундаалдаг болохоор л тэднийг харж чадаж байгаа юм. Өглөө эрт, үүр цайх үед ус уухаар ирдэг. Оройдоо, нар шингэх үед чимээ аниргүй болоход толгодын дээгүүр зээр ба хулан харагддаг. Нохой л тэднийг хараад хөөхгүй бол тэд усандаа бөөнөөрөө цуглардаг. Тэгээд л туурай нь түжигнээд л манай хонины цаагуур давхиад л алга болно. Туурайн төвөргөөн ч гайхалтай сонсогдоно шүү. Ойролцоогоор мянгаад хулан энэ нутагт идээшилж байна.

Лена: Тахийг сэргээн нутагшуулсан явдлыг та юу гэж бодож байна вэ?
Галбадрах: Тахийг буцааж авчирсан нь их зөв зүйл гэж боддог. Эрт дээр үед энэ нутагт амьдарч байсан. Одоо төрөлх нутагтаа аюулгүй, эрх чөлөөтэй идээшилж байгааг нь харахад үнэхээр сайхан.
Ариунжаргал: Энэ их сайн зүйл болсон гэж бодож байна.

Лена: Та байгаль хамгаалагчидтай тааралддаг уу?
Галбадрах: Өө нэлээд таарна шүү. Тахь, хулан ундаалсан талаар болон бусад зүйлийн талаар ярилцдаг.

Лена: Нэмж олон тахь нутагшуулах талаар та юу гэж бодож байна вэ?
Галбадрах: Энэ их зөв сайн зүйл. Цаашдаа ч ховордсон төрөл зүйлийг буцааж байгальд нь нутагшуулах ажил үргэлжилнэ гэж найдаж байна.
Ариунжаргал: Тийм шүү, их сайн ажил, үргэлжлүүлж хийгээсэй.

Лена: Зэрлэг амьтад болон малчдын мал сүргийн аль альных нь хувьд, тус бүс нутаг дахь хур тунадасны хувьсах шинжээс шалтгаалж бэлчээрийн чанар хангалттай байж чадаж байна уу?
Галбадрах: Бэлчээрийн чанар жилээс жилд улам л муудсаар байна. Энэ нь байгаль өөрөө сүйрч байгаагаас болж байж болно. Одоогоор сайн ч биш муу ч биш дундаж түвшинд л байна. Хэрэв цас ихээр унавал амьтад болон малчдын аль алинд нь хэцүү, эрсдэлтэй байх болно. Бид энэ нөхцөл байдлыг сүүлийн 2-3 жил ажиглаж байна.

*Малчин **Галбадрах, Лена Михлерын** судалгаанд оролцож байгаадаа сэтгэл хангалуун байдаг. **Лена Михлер** бэлчээрийн тогтвортой байдал болон хамгаалалттай газар нутгийн хамтын менежментийн стратегийг боловсруулж байгаа ба хорин ямаанд жил гаруй хугацаанд GPS-тэй хүзүүвч зүүж хөдөлгөөнийг нь ажиглаж байна*

Зураг: Лена Михлер

2019 оны зорилтууд: ОУТГ-д тулгамдаж буй асуултууд[1]

***Ребека Блумер,** ОУТГ-ийн санхүүч.*

Би жил бүр Зул сарын баярын өмнө төрөл бүрийн байгууллагуудаас ирсэн захидалд их дарагддаг. Яагаад ОУТГ-д хандив өгөх ёстой вэ? гэсэн захиануудыг ирдэг.

Үүнд цөөхөн хэдэн шалтгаан бий. Юуны өмнө, байгаль хамгаалах ажилд сайн санааны буяны хандив үнэхээр бага хувьтай ирдэг - Швейцарт гэхэд ойролцоогоор 10% л байна. Бид байгаль дээр л оршин амьдарч байж яагаад өөрсдийн хувийн зорилгуудаа өөрөөр тодорхойлж болохгүй гэж? Хоёрдугаарт, ОУТГ-д ирсэн хандив нь хөтөлбөртөө ашиг тусаа бүрэн өгдөг. Удирдах зөвлөл нь ямар нэгэн цалин хөлсгүй ажилладаг. Гуравдугаарт, Зүүнгарын говийг хамгаалснаар бид ЮНЕСКО-ийн биосферын нөөцийг болон дэлхий дээрх тал хээрийн экосистемийн хамгийн сүүлийн хөндөгдөөгүй үлдсэн өвөрмөц амьдрах орчныг хамгаалах болно. Гэхдээ бидний өчүүхэн санхүүжилтийн улмаас энэхүү орон зай нь хараахан танигдаж чадаагүй байна. Дөрөвдүгээрт, байгальд өмнө нь устсан амьтны мега төрөл зүйл болох Пржевальскийн зэрлэг адууг (Тахь) сэргээн нутагшуулсан явдал нь бидний гайхамшигтай амжилтыг батлан харуулж байна. Мөн бид орон нутгийн айл өрхүүдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлж, тэр ч байтугай дархан цаазат газрын дотор уламжлалт нүүдэлчдийн амьдралын хэв маягийг хэвээр хадгалахыг дэмжиж байна. Үүнээс өөр шалтгаан хэрэгтэй юу, эсвэл одоо танд төлбөрийн хуудас өгөх үү (инээв)?

2019 онд ямар зорилтуудыг тавьж байна бэ?

Дархан цаазат газрын мониторинг судалгаа, тахийн сэргээн нутагшилтыг талаарх тоо баримтыг цуглуулах, төслийн талаар мэдээлэл хийх зэрэг ОУТГ-ын үндсэн ажлууд жилээс жилд хэвээр үргэлжлэх болно. Эдгээрт Улаанбаатар дахь ОУТГ-ийн ажилтнууд болон байгаль хамгаалагчдын цалин хөлсөөс гадна жил бүр нийт 90’000 ШФ-ын бусад зардал (хүснэгтээс харна уу) шаардагдана. Энэ зардлыг бид үнэнч хандивлагчдынхаа өгсөн том, жижиг хандиваар зохицуулдаг. Тийм болохоор зэрлэг адуу болон тэдгээрийн экосистемийг хамгаалах нь тэдэнд ч бас хамаатай асуудал юм. Энэ завшааныг ашиглан байгаль хамгаалах чухал ач холбогдол бүхий энэхүү хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжийг олгож байгаа хандивлагчиддаа дахин чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Өдөр тутмын хийдэг эдгээр ажлуудаас өөр ямар ажил, үүрэг хүлээж байна вэ?

Байнга хийдэг эдгээр ажлууд нь манай төслийн хамгийн чухал ажил нь юм. Тийм ч сонирхол татсан, гайхамшигтай биш байж болох ч цаашид нээгдэх бүх боломжийн суурь болдог. Гэхдээ нэмэлт ажлууд хийгдэнэ. Энэ жилийн хувьд зургаан ажлыг төлөвлөөд байна. Үүнд: менежментийн төлөвлөгөөний 3 дахь семинарыг зохион байгуулах, 2020 онд говь, хээрийн том хөхтөн амьтдын цэгэн тооллого хийх, судалгаа шинжилгээний төслүүд, усны менежментийг хэрэгжүүлэх, ДЦГ-ын өргөтгөл, хил дамнасан хамгаалалттай газрын сүлжээг байгуулах урт хугацааны зорилгыг албажуулах зэрэг ажлууд орж байна. Цюрихийн Зэрлэг байгалийн хүрээлэнд болох семинарт бид судалгааны төслууд болон ОУТГ-ийн уйл ажиллагааг Монголын тахь нутагшуулах үндэсний хөтөлбөртэй холбож хээрийн ажил, үйл ажиллагааны чиглэлээ мэргэжлийн түвшинд хүргэнэ.

Хөхтөн амьтны тооллогын талаар хэрхэн ойлгох вэ? Яагаад хэрэгтэй вэ?

Тодорхой ажиглалтын цэгүүдэд хэд хэдэн төрөл зүйлийн тооллогыг системчилсэн байдлаар тогтмол явуулах нь онгон байгалийн менежментийн чухал үндэс юм. Үүнийг NINA (Байгаль орчны Норвегийн хүрээлэн, Трондхейм) болон FIWI (Зэрлэг амьтдын экологийн судалгааны хүрээлэн, Вена)-ийн мэргэжилтнүүд хамтран удирдан, зохион байгуулж байна. 2020 онд явуулах нэлээд хүч хөдөлмөр шаардсан энэхүү нарийн төвөгтэй тооллого, зураг зүйг цаг тухайд нь гүйцэтгэх, сайн дурын ажилтнуудыг оруулаад нийт 50 орчим хүнийг элсүүлэх, сургах, тоног хэрэгслээр хангах бэлтгэл ажил ирэх жил эхлэх ёстой. Эдгээр зорилтуудыг биелүүлэхэд 25’000 ШФ-ийн зардал гарахаар тооцоолоод байна.

Та бүхэн ямар төрлийн судалгаа хийж байна вэ? Суурь судалгаа юу эсвэл үйл ажиллагааны судалгаа юу?

Аль аль нь. Зэрлэг амьтныг хамгаалах менежментийг бүрэн утга учир, мөн чанараар нь хийхэд нотолгоонд суурилсан байх ёстой ч Зүүнгарын говийн экосистемийн талаар олон чухал асуултууд хариултгүй үлдэж байна. Тийм ч учраас өнгөрсөн жил бид зэрлэг амьтны нэртэй биологич Доктор Петра Каченскигаар удирдуулсан судалгааны зөвлөлийг байгуулсан юм. Уг зөвлөл нь 2017 онд хэлэлцэн тохиролцсон судалгааны 9 төслийг удирдан хэрэгжүүлэх юм. Тухайлбал, Лена Михлерийн нийгэм-эдийн засгийн судалгаагаар онгон байгалийг газар ашиглаж ирсэн уламжлалтай нийцүүлэн хамгаалах суурь зарчмыг танилцуулах болно. Биологийн олон янз байдлын мониторинг, зэрлэг амьтан болон малын аль аль нь хэрэглэдэг усны эх үүсвэрийн халдвартай бичил биетний судалгаа, эсвэл тахийн генетикийн судалгаа зэрэг бусад жишээнүүдийг дурдаж болно. Үүнд бид 2019 онд 20’000 ШФ-ийг зарцуулахаар байна.

Усны менежментийн зорилго юу вэ?

Говийн их дархан цаазат газрын “Б” хэсэг нь цөлөрхөг хээрийн бүсэд хамаардаг учраас усны ашиглалтад их анхаарах шаардлагатай. Бид Тахийн тал дахь Хамгаалалтын захиргааны байрыг 2016 онд өрөмдсөн цооногоос зөөврийн усаар хангаж, урсгал устай ариун цэврийн байгууламжтай болгохыг хүсч байна. Гэвч говьд температурын ялгаа (+ 50 ° C -аас -50 ° C) их байдаг учраас бүрэн шийдвэрлэхэд маш хэцүү байна. Үүнээс гадна Бижийн гол, байгалийн булаг шанд, зэрлэг амьтдын шилжин нүүдэллэх чиглэлийн дагуу боломжит газар нь хиймлээр гаргасан усны цэг зэргийг ашиглах үзэл баримтлал бидэнд хэрэгтэй. Энд хамгийн багадаа 65’000 ШФ-ийн зардлыг шаардах болно.

Та дархан цаазат газрын хил дамнасан сүлжээг байгуулах тухай дурдаж байсан. Энэ ямар учиртай вэ?

Говь, цөлийн том хөхтөн амьтдын хувьд хувьсан өөрчлөгдөж байдаг байгалийн нөөцийг дагаж нүүдэллэн явахад нь маш том орон зай шаардлагатай байдаг. Тиймээс ОУТГ нь эхний ээлжинд Зүүнгарын говийн хамгаалалттай газар нутгийг өргөжүүлж, урт хугацаандаа Говийн их дархан цаазат газрын “А”, “Б” хэсгүүдийг Хятадын Каламайлийн байгалийн нөөц газартай холбосон нүүдлийн корридор нутаг байгуулах зорилготой. Ингэснээр дэлхийд хамгийн том хил дамнасан тусгай хамгаалалттай газрын сүлжээг үүсгэх юм. Монгол, Хятад улсын улс төрийн болон ложистикийн нөхцөл байдлыг үнэлж үзэхэд, ялангуяа ашигт малтмалын хайгуулын хувьд өрсөлдөх сонирхол их байгаа учраас бид энэхүү үйл хэргийн төлөө тууштай, эрч хүчтэй ажиллах хэрэгтэй. Дархан цаазат газрын нутаг дэвсгэрийн хэмжээг 1 сая га-гаар өргөтгөх талаарх эхний зөвлөгөөн дээр орон нутгийн засаг захиргааны дэмжлэгийг бүрэн авч Монгол Улсын Засгийн газарт өргөн барьсныг 2018 оны 9-р сарын 6-ны хурлаар хэлэлцэн дэмжсэн бөгөөд УИХ-ын намрын чуулганы хугацаанд хэлэлцэх асуудлын жагсаалтанд орсон тул цаашид дэмжигдэнэ гэдэгт гүнээ найдаж байна. Та бүхэн бидэнд амжилт хүсээрэй.

[1] Interview: Ki

“Байгаль хамгаалах ажилд маш бага хувьтай буяны хандив ирдэг - Швейцарт гэхэд ойролцоогоор 10% л байна. Бид байгаль дээрээ л оршиж байгаа мөртлөө яагаад өөрсдийн хувийн зорилгуудаа тийш нь чиглүүлж болохгүй гэж?”

Тахь Усны нарны эрчим хүчээр ажилладаг шинэ худаг

Тахь Усны ундны усны гол ундарга нь худгийн гүний цооногтоо байдаг. Тухайн худгийн хажууд тахийн сүргийг дасгах зорилгоор 2016 онд шинэ хашаа барьсан юм. Энэ жил "Solar Tech" ХХК нь нарны эрчим хүчээр ажилладаг насосыг худагт шинээр тавьжээ. Мөн худагт цооногын усыг хурааж тэндээсээ тахь нутагшуулах хашаа, хашааны гаднах цөөрөм рүү усыг урсгаж зэрлэг амьтан болон нүүдлийн малын услах боломжтой болгосон.

*ГИДЦГ Б хэсгийн захирал **О. Ганбаатар** (зүүнээс хоёр дахь нь) нарны эрчим хүчний техникч, байгаль хамгаалагчдын багийн хамт цооногийн усыг хураах худгийн дэргэд. Баруун талд "Терра Матер" сэтгүүлд Тахийн тухай тайлан бичсэн Стефан Шоманн.*

Нутагшуулах шинэ хашаан дахь худаг руу ус цалгилан орж байгаа нь. Шар айрагны лаазуудыг мэдээж зэрлэг адуунд тавиагүй шүү...

2019 онд ОУТГ ямар ажил хийх вэ?

Үйл ажиллагаа	Шаардлагатай санхүүжилт
Үндсэн ажил (Тахь болон ДЦГ-ын мониторинг судалгаа, Хамгаалалтын захиргаа, ОУТГ-ийн Монгол дахь товчооны үйл ажиллагаа, мэдээлэл / холбоо харилцаа, машин, техникийн хангамж, өвлийн бэлтгэл, эрсдлийн үеийн өвс хадлан, нарны худгуудын засвар, үйлчилгээ, бусад тоног төхөөрөмж, нутагшуулах хашааны арчилга).	**ШФ 90'000.-**
2020 онд явуулах том хөхтөн амьтдын цэгэн тооллогын бэлтгэл.	**ШФ 25'000.-**
Судалгааны төслүүд	**ШФ 20'000.-**
ДЦГ-ын усны менежмент	**ШФ 65'000.-**
ДЦГ-ын өргөтгөл болон хил дамнасан тусгай хамгаалалттай газрын сүлжээ	**Тодорхойлох шаардлагатай**



Дархан цаазат газарт тахийн тоо 235-д хүрсэн нь цаг үеийн хамгийн өндөр үзүүлэлт болсныг тоо толгойн хэлбэлзлийн графикаас харж болно.

Хамтдаа бүтээцгээе!

Эрхэм хүндэт уншигч та манай үйл ажиллагаа, хөтөлбөрийг ямар нэгэн байдлаар дэмжихийг (веб дизайн, харилцаа холбоо, дэмжлэг тусламж, барилга, төслийн менежмент гэх мэт) хүсвэл Олон улсын тахь групп буюу (rebekka.blumer@sannet.ch) хаягаар холбогдоорой. Тахь, түүний экосистемийн хамгаалах үйлсэд сайн дурааараа зүтгэж буй манай хамт олон бүхий л төрлийн дэмжлэг туслалцааг хүлээн авахдаа таатай байх болно. Өөрийн санаа эрч хүчээ бидэнтэй нэгтгээрэй. Говийн экосистемийг хамгаалах үйлсэд хийх ажил их байгаа тул та Удирдах зөвлөлийн гишүүн уу биш үү гэхээс үл хамааран таны санаа санаачлагыг бид хүлээн авахдаа баяртай байх болно. Мөн та Тахийн талыг өөрийн нүдээр харж, үнэ төлбөргүй буудаллах боломж байгааг дуулгахад таатай байна. Энэ бол багцын нэг хэсэг юм!

Тахийг сэргээн нутагшуулахад
Монгол улсаас үзүүлж буй дэмжлэг

Өнөөдөр Тахийг нутагшуулах ажлыг санхүүжүүлж байгаа хандивлагчдын дийлэнх нь Европт байна. Анхаарал хандуулж буй уг асуудлын талаарх ойлголтыг сайжруулахын тулд энэ зун ОУТГ-ийн төлөөлөгчид Монголд нэлээд олон эрх бүхий байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, аялал жуулчлалын компаниуд болон сангуудаар зочилсон. "Тахийн нөхөд" санг үүсгэн байгуулснаар бид орон нутгийн үнэ цэнэтэй дэмжлэгийг авч байна. Манай санд Говь-Алтай аймгийн сайн малчин Б. Даваа, Ховд аймгийн Алтай сумын Иргэдийн хурлын дарга Н.Бүргэд, Алтай сумын засаг даргын орлогч Б.Алтангэрэл , ЗДТГ-ын дарга Д. Баатарсүрэн, Барлаг багийн засаг дарга М.Эрдэнэсүрэн, Монголын байгаль зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн экологич Доктор Ж. Сэргэлэнхүү, Чингис пивоны үйлдвэрийн хамтран эзэмшигч Альфред Наеф, Хөрс автосервис ХХК-ийн захирал Ч. Гантулга зэрэг хүмүүс энэ онд элсэн оржээ.

Шинэ гишүүдийн тоонд бас "Nomadic Journeys" болон "Nomin Holding" ХХК компаниуд орно. "Nomadic Journeys" ХХК нь Монгол улсын хамгийн анхны аялал жуулчлалын байгууллагуудын нэг юм. Хатагтай С. Мандухай захиралтай тус компани нь 1993 оноос эхлэн олон улсын болон дотоодын аялал жуулчлал эрхлэгчид, орон нутаг, байгаль хамгаалдаг бүлгүүдтэй хамтран ажилладаг ба байгаль орчинд ээлтэй адал явдалт аялалыг зохион байгуулж монгол оронд 1000 гаруй жуулчдыг жил бүр аялуулдаг байна.
"Номин Холдинг" ХХК нь Монгол улсын томоохон компаниудын нэг бөгөөд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүүгийн салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Компанийн Удирдах Зөвлөлийн гишүүн, адуунд дурлагч Проф. Др. А.Шагдарсүрэн тахийн "Ажнай" азаргатай сүргийн энэ жилийн анхны унаганд "Номин" нэрийг хайрласан.

Мөн Deepsurvey ХХК-ийн захирал Дугарын Ганболд, Монгол улс дахь Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын элчин сайд Стефан Дуппелийн гэр бүл, Норвеги улсын иргэд Елизабет Хүрлен болон Фредрик Штрём нар тахийн унагыг ивээн тэтгэж байна.
ОУТГ нь хувь хүмүүс, компаниуд, сангийн дэмжлэгэнд туйлын сэтгэл өндөр байдаг ба тэдэндээ чин сэтгэлээс талархаж байна.

Ч.Гантулга (дунд баруун талд) 2010 оны зуднаар өвс тэжээл яаралтай хүргэхэд шатахууны машин илгээж тусалж байв. Мөн тэрээр жил бүр 500'000 төгрөгийн (200 ШФ) дэмжлэгийг шатахуун хэлбэрээр ОУТГ-д хандивладаг! Зүүн ба баруун захад: Жамъядоржийн Батсүх ба Намтарын Энхсайхан (Монгол дахь ОУТГ). Дунд зүүн талд: Ребекка Блүмер (ОУТГ-ийн УЗ)

Профессор А. Шагдарсүрэн Н. Энхсайханы хамт. Ажнай сүргийн анхны 2018 оны унага "Номин"-гийн нэрийг "Номин Холдинг" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн профессор А. Шагдарсүрэн өгсөн юм.

"Тахийн нөхөд" санг үүсгэн байгуулснаар бид орон нутгийн үнэ цэнэтэй дэмжлэгийг авч байна.

NOMADIC JOURNEYS
SINCE 1993

"Тахийн нөхөд" сантай нэгдсэн анхны монгол компани нь "Nomadic Journeys" ХХК юм. Хатагтай С. Мандухайгаар удирдуулсан энэ компани нь хүрээлэн буй орчинд ээлтэй аялал жуулчлал зохион байгуулдаг.

Зүйлийн тодорхойлолт: Мануул

© Зураг: О. Баатаргал 2018

Урт үстэй, богино хөлтэй, чих нь доогуур, хавтгай нүүртэй, дугуй хүүхэн хараатай, гэрийн муурны хэмжээтэй мануул нь (Palla's Cat, Otocolobusmanul) этгээд сонин амьтан юм.

Тийм ч болохоор муурын бусад төрөл зүйлээс бараг 6 сая жил тусгаарлагдан оршиж байгаа болов уу. Мануул нь Каспийн тэнгисээс Монголын зүүн хэсэг хүртлэх Төв Азийн тал хээр, уулархаг бэлчээр нутагт болон Төвдөд далайн түвшнээс дээш 5000 метрийн өндөрт амьдардаг. Түүний үндсэн тархац газар нь монгол орон юм.

Мануул нь бараг 6 сая жилийн туршид тусгаарлагдан оршиж муурны өврийн гэсэн нэг төрөл зүйлийг бий болгосон байна.

Өөрөө жижиг махчин амьтан болохоор том махчин амьтад болон махчин шувууны идэш тэжээл болдог учраас нуугдмал амьдралтай. Мануул тал хээрт ховор тохиолддог. Тарваганы орхисон нүх, хад чулууны хонгил зэрэг нуугдмал газарт үүрлэдэг. Мануулын нягтшил маш бага. Монгол орны хувьд хамгийн тохиромжтой амьдрах орчин нь 100 км2 талбайд зөвхөн 2-6 бодгаль оногдож байна. Энэ өвөрмөц, нуцлагдмал, сайн танигдаагүй төрөл зүйлийг хамгаалахад маш их орон зай хэрэгтэй.

Мануулыг хамгаалах зайлшгүй шаардлага байна. Малын тоо толгой нэмэгдэж бэлчээрийн талбай өргөжиж, ашигт малтмалын хайгуул ихээр хийж байгаа нь энэ нуугдмал муурыг амьдрах орчноос нь шахаж байна. Агнах, шахах, айлын малчин ноход болон бусад махчин амьтад нь мануулын хорогдлын гол шалтгаан болоод байна. Зөвхөн монгол оронд гэхэд л урхинд орсноос гадна жил бүр 2000 орчим мануулыг арьсыг нь авах зорилгоор агнасан байна. Түүнчлэн мануулын гол идэш тэжээл болох - үлийн цагаан оготно, чичүүл, огодой, барагчин, зурам болон бусад мэрэгчдийг хортон шавьжны хяналтын хөтөлбөрүүдийн нөлөөгөөр хордуулан устгаж байгаа нь мануулыг идэш тэжээлийн гол нөөцөөс нь хагацуулж байна.

Нэлээд хомс мэдээлэлд суурилсан ч Дэлхийн байгаль хамгаалах холбооноос (IUCN) мануулын үлдсэн тоо толгойг 2.3 сая кв.км тархац газарт (EX-ны нутаг дэвсгэрийн тал) 15 000 гэж тооцоолсон байна. Мануул нь аюулд өртсөн, ховордож болзошгүй гэсэн ангилалд багтсан ба Зэрлэг амьтан ба ургамлын ховордсон зүйлүүдийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Вашингтоны конвенц (CITES)-ийн II хавсралтанд бүртгэгдсэн дэлхийн ховор амьтан юм. Гэсэн ч тархац нутгийн хамардаг бусад улс оронтой харьцуулахад монголд мануулыг хамгаалахгүй байна, аль ч улс оронд түүнийг хууль бусаар агнах ёсгүй.

Амьтны хүрээлэнд зөвхөн цөөхөн хэдэн мануул байдаг ба энэхүү хээр талын өндөрлөг газрын муурыг эрүүл байлгах амаргүй байна. Тэнд байгаа мануулуудыг хээлтүүлдэг ч үр төлийн бараг тал хувь нь халдвараас болж эхний 30 хоногтоо үхдэг. Тийнхүү амьтны хүрээлэнгүүдэд энэхүү төрөл зүйлд аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх нь бараг боломжгүй болов уу. "Тал хээрийн зэрлэг амьтан хамгаалах болон Судалгааны төв" -ийг үүсгэн байгуулагч биологич Баатаргал нар Монгол улсын зүүн өмнөд хэсэгт (Сүхбаатар аймагт) энэ өвөрмөц төрөл зүйлийн муурыг баримтжуулж, хамгаалж байгаа нь найдварын эхлэлийн цэг болж байна.

[1] Selles, H. 2013. The relative impact of countries on global natural resource consumption and ecological degradation. International Journal of Sustainable Development World Ecology 20: 97-108.
[2] Ross, S. 2009. Providing an ecological basis for the conservation of the Pallas's cat (Otocolobus manul). University of Bristol.
[3] https://www.iucnredlist.org/species/, Zugriff 16.10.2018

Steppe Wildlife Conservation & Research Center

Түүний үндсэн тархац газар болох Монгол улсад бусад улс оронтой харьцуулахад мануулыг хамгаалахгүй байна.

Таны тусламж бидэнд хэрэгтэй.

Байгаль хамгаалах ажил үргэлж гайхамшигтай, сүр дуулиантай байдаггүй. Ялангуяа дадал болсон ар талын ажлыг амжилттай төсөл болгох нь амаргүй ажил юм. Тиймээс таны өгсөн хандив тусламжаар хичнээн өөрчлөлт хийж болохыг та эндээс харж болно. Өгч буй хандив бүр бидэнд үнэ цэнэтэй бөгөөд бид таатай хүлээж авах болно.

40.000 төг
Байгаль хамгаалагчийн нэг өдрийн хөлс
(цалин, материалын зардал)

120.000 төг
Машин техникийн шатахууны үнэ

200.000 төг
Байгаль хамгаалагчдын машины засвар сэлбэг

300.000 төг
Аргаль, Янгирт зориулсан нарны эрчим хүчээр ажилладаг гүний худаг барихад зориулна.

500.000 төг
Байгаль хамгаалагчдийн нэг сарын унааны зардал

1.000.000 төг
2020 онд зэрлэг ан амьтдыг тоолох байгаль хамгаалагчдад зориулсан сургалтад хувь нэмрээ оруулна.

“Тахийн нөхөд“-сангийн эгнээнд элсэх боломж Танд байна!

- Хувь хүний гишүүнчлэлийн жилийн хураамж **100,000 төгрөг**
- Оюутан, залууст зориулсан “Унага” гишүүний хураамж **40,000 төгрөг**

Хандивын данс

ХААН банк, данс 5166 4298 97

ХХБ, данс 4526 0346 0

Хүлээн авагч: Тахийн нөхөд сан

Олон улсын тахь групп нь сайн дурын үндсэн дээр ажилладаг ба таны хандивласан төгрөг бүр тахь нутагшуулахад зориулагдана.

Эрхлэн гаргасан
Олон Улсын Тахь Групп нийгэмлэг
Тахийн нөхөд Вилдниспарк Цюрих сан
Алтэ Зийлталштрассэ 38
CH-8135 Зийлвалд
Швейцар улс
www.savethewildhorse.org
info@savethewildhorse.org
itgmon@gmail.com
takhifriends@gmail.com

ITG INTERNATIONAL TAKHI-GROUP

ГОВИЙН ИХ ДАРХАН ЦААЗАТ ГАЗАР “Б”
GREAT GOBI “B” SPA

Байгаль орчинд ээлтэй цаасан дээр хэвлэв. FSC (Ойн Удирдах Зөвлөл) / ЕХ Эко шошгоны цаас